



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Мерси Кор Монгол Олон улсын байгууллагаас мал аж ахуйн үйлдвэрлэл, экспортыг дэмжиж, малчид, бизнес эрхлэгч, төрийн байгууллагуудын хямрал, саад бэрхшээлийг даван туулах чадварыг бэхжүүлэх замаар нийгмийн сайн сайхан, тогтвортой хөгжлийг хангах зорилготой “Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд хөтөлбөр”-ийг 8 аймагт хэрэгжүүлж байна.

Тус хөтөлбөрийн зүгээс дараах тоног төхөөрөмжийг нийлүүлэх байгууллагыг сонгон шалгаруулна:

1. Мал эмнэлгийн вакцин хадгалах хөргүүр – 21 ширхэг

Техникийн тодорхойлолт

Стандарт шаардлага: Европын Холбооны СЕ тэмдэглэгээтэй

Дотор хэмжээ: 600 x 1100 x 1400 мм-ээс багагүй

Багтаамж: 650 литр ба түүнээс дээш

Дотор тасалгаа: зэвэрдэггүй ган

Хаалга: цантаж мөстөхөөс сэргийлсэн давхар шил, бөх бат

Температурын горим: +2-оос +8°C

Дохиолол: температур ихсэх, багасах, мэдрэгчид алдаа гарах, тэжээл, батарей багасах зэрэгт ажилладаг байх

Дотор гэрэл: байх

2. Мал эмнэлгийн лабораторийн халдвартай хог хаягдал шатаах зуух – 1 ширхэг

Техникийн тодорхойлолт

Стандарт шаардлага: Европын Холбооны СЕ тэмдэглэгээтэй

Ажлын камер: 600 x 600 x 800 мм-ээс багагүй

Ажиллах горим: цахилгаан ба түлшээр

Ажиллах температур: 1000°C-ээс багагүй

Өвөл, зуны цаг агаарт саадгүй ажиллах

Хорт утаа ялгаруулахгүй байх

Хүлээлгэж өгөх газар: Хөвсгөл аймгийн Мөрөн хот

Тендерт бүрдүүлэх материал:

- Тендерт материал ирүүлсэн тухай албан тоот
- Нийлүүлэгч компаний улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Нийлүүлэгч компаний товч танилцуулга
- Харилцагч банкны тодорхойлолт
- Сүүлийн 2 жилийн хугацаанд тендерт заасантай ижил төстэй бараа бүтээгдэхүүн борлуулсан мэдээлэл, хүлээн авсан байгууллагуудтай холбогдох хаяг
- Сүүлийн 2 жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ, жагсаалт

- Нийлүүлэх бүтээгдэхүүний техникийн тодорхойлолт
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн мэдээлэл
- НӨАТ, тээврийн зардлыг багтаасан үнийн санал
- Нийлүүлэлт буюу угсралт суурилуулалтын хугацаа
- Баталгаат хугацаа

Тендерт оролцогч битүүмжлэл бүхий материалаа 2017 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 10:00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлнэ үү.

Мерси Кор Монгол ОУБ

Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо, АОС-30-1

Утас: 461145; Факс: 461048

И-мэйл: mn-contactus@mercycorps.org